



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 20 дугаар

Дугаар A)350

Хэрлэн сум

Хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1.1, 70.1.2, 70.1.3, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль зохион байгуулагдаж байгаатай холбогдуулан 2024 оны 06 дугаар сарын 27-оос 2024 оны 06 дугаар сарын 29-ний өдрүүдэд аймгийн хэмжээнд согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдахыг, 2024 оны 06 дугаар сарын 28-ний өдөр соёл урлаг, үзвэр, спортын зэрэг олныг хамарсан аливаа арга хэмжээ зохион байгуулах, гадаа болон битүү талбайд үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний төвийг ажиллуулахыг хориглосугай.

2. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуй нэгж, байгууллагыг мэдээллээр хангаж, захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг аймгийн Цагдаагийн газрын дарга (Хурандаа Э.Жавхлантөгс)-д, сумын Засаг дарга, тосгоны Захирагч наарт тус тус даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Б.Дарханбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ